

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ СОНГОН ШАЛГАРУУЛТАД УРЬЖ БАЙНА**

2025.10.15

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газраас Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 107 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх үнэлгээний байгууллагын сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Нэг. Үндсэн зорилго

Төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээний чанар, хүртээмж, хүнд суртал, ил тод хөнгөн, шуурхай байгаа эсэх талаарх иргэдийн хандлагыг тандан судалж, хөндлөнгийн үнэлгээ өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, зөвлөмжөөр хангахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, иргэдэд хэрхэн хүрч байгаад үнэлгээ өгөх;
2. Иргэдээс цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал, асуулга, судалгаа хийх;
3. Иргэдээс авсан санал асуулга, судалгааны дүнд үндэслэн үйлчилгээг сайжруулах талаар цаашид авах арга хэмжээний зөвлөмж, чиглэл боловсруулж, ирүүлэх.

Хоёр. Хэрэглэгчийн үнэлгээний хамрах хүрээ, түүврийн хэмжээ

А. Үнэлгээний хамрах хүрээ

1. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд өгч буй иргэдийн үнэлэмжийг судлах;
2. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, цэгүүдийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийх;

Б. Түүврийн хэмжээ

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад “тухайн аймаг, нийслэл,

сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулна” гэж заасны дагуу статистикийн хувьд хүчинтэй түүврийн хэмжээнд хамруулна.

Гурав. Үнэлгээ хийх байгууллагад тавигдах шаардлага

А. Хэрэглэгчийн үнэлгээ хийх хөндлөнгийн үнэлгээний байгууллага дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Судалгаа, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
2. Санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх /Багийн ахлагч эсвэл аль нэг гишүүн нь эрх зүй, төрийн удирдлагын чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, судалгааны чиглэлээр мэргэшсэн байх/;
3. Үнэлгээг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэх чадвартай байх;
4. Байгууллага иргэдээс авах санал асуулгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн хавсралт-2 /Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах санал асуулгын хуудасны ерөнхий загвар/ дагуу бэлтгэх.

Б. Сонгон шалгаруулалтад оролцох судалгааны багийн бүрдүүлэх материал:

1. Судалгаа хийх сонирхлоо илэрхийлсэн албан бичиг;
2. Судалгааны баг, байгууллагын товч танилцуулга;
3. Судалгааны багийн гишүүдийн танилцуулга;
4. Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлагын талаарх мэдээлэл;
5. Судалгааны ажлын удирдамж;
6. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө болон үнийн санал.

Дөрөв. Хэрэглэгчийн үнэлгээнд тавигдах шаардлага, тайлагналт

Хэрэглэгчийн үнэлгээг тавигдах шаардлагын түвшинд нэгтгэн гүйцэтгэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан хүснэгт-3 /Тайлагналт ба хугацаа/, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн хавсралт-3 /Тайлангийн бүтэц/ дагуу гаргаж, дүнг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

Тав. Сонгон шалгаруулалтын материал авах хугацаа, байршил

Сонгон шалгаруулалтын материалыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 08 цаг 00 минутаас 12 цаг 00 минут, 13 цаг 00 минутаас 17 цаг 00 минут хүртэл доорх хаягаар хүлээн авна.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар;

Утас: 7000-7593, 7011-8183;

Цахим хаяг: bat.lkhagvasuren@burtgel.gov.mn

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР